



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Аудитын нэр: "Орон нутгийн хөрөнгийн эргэн төлөгдөх зээлийн сангуудын үйл ажиллагаа, үр дүн"-д хийх гүйцэтгэлийн аудит

ХӨА-2018/02/-ГА

Монгол Улсын Ерөнхий аудиторын
2018 оны А/125 дугаар тушаал,
Монгол Улсын Ерөнхий аудиторт
Хөвсгөл аймаг дахь Төрийн
аудитын газраас 2018 онд
нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил
үйлчилгээний төлөвлөгөөг
үндэслэн гүйцэтгэсэн
гүйцэтгэлийн аудитын тайлан

**САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД
ТАВИХ ХЯНАЛТ ХАНГАЛТГҮЙ
БАЙГААГААС ТӨСЛИЙН
АШИГЛАЛТ, ҮР ДҮН БУУРСАН
БАЙНА.**

**Хөвсгөл аймаг
Мөрөн сум 2018**



2014.05.29 нд "Аймгийн үйлдвэржилтийг дэмжих сан"-аас олгогдсон 80.0 сая төгрөгийн "Нийтийн халуун ус" төсөл одоо болтол бүрэн хэрэгжээгүй, үр дүнгүй болсон байна.



2014.05.16 нд "Аймгийн үйлдвэржилтийг дэмжих сан"-аас олгогдсон 50.0 сая төгрөгийн "Хөнгөн блокны үйлдвэр одоо болтол бүрэн хэрэгжээгүй, үйл ажиллагаа нь зогссон байна



Тайланг бэлтгэсэн:

**Хөвсгөл аймаг дахь
Төрийн Аудитын газар**

ХӨА-2018/02/-ГА

Хөвсгөл аймаг дахь Төрийн
аудитын газрын дарга бөгөөд
тэргүүлэх аудитор

О.Ганболд

Аудитын менежер

Ж.Отгончимэг

Аудитор

Э.Бат-Эрдэнэ

2018 оны 11 дүгээр сар

**Уг тайланг УАГ-ын цахим
хуудаснаас үзнэ үү.
www.audit.mn**

Аудитын тайлан, дүгнэлттэй
холбоотой асуудлаар
70384043 дугаарын утас,
70383793 дугаарын факсаар
харилцана уу?

ХАЯГ: (Хөвсгөл аймгийн
ЗДТГ-ын А байр 3 давхарт)

АГУУЛГА

- ❖ Товчилсон үгийн жагсаалт 2
- ❖ Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдээлэл 3-4
- ❖ Тайлангийн хураангуй

Ерөнхий зүйл

БҮЛЭГ-1. Төсөл хөтөлбөрийг гэрээ, журамд заасан заалттай нийцүүлэн сонгон шалгаруулаагүй байна. 6-12

1.1. Сангийн хөрөнгийн эргэн төлөлт хэвийн байна.

1.2. Зээлийн ашиглалт, үр дүн сум бүрт харилцан адилгүй байна.

БҮЛЭГ-2. Сангийн хөрөнгийн зарцуулалтад холбогдох байгууллагууд хяналт тавиагүй байна. 13-15

2.1. Сангийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй төслийн үйл ажиллагаанд хяналт тавиагүйгээс шалгарсан төслүүд хэрэгжихгүй, үр дүнгүй болох нөхцөл бүрдсэн байна.

2.2. Эрх бүхий албан тушаалтнууд сангийн үйл ажиллагаатай холбоотой үүргээ хэрэгжүүлээгүй, хөрөнгийн зарцуулалтад хяналт шалгалт хийгээгүй байна.

Дүгнэлт.....

Зөвлөмж.....

16-17

Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал

Хавсралт

Зөрчлийн жагсаалт.....

Тэргүүлэх аудиторын тушаал

Товчилсон үгийн тайлбар

Товчилсон үг	Тайлбар
УИХ	Улсын Их Хурал
ХӨА	Хөвсгөл аймаг
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ҮАГ	Үндэсний аудитын газар
ГАГ	Гүйцэтгэлийн аудитын газар
ХөААГ	Хөвсгөл аймгийн аудитын газар
ГА	Гүйцэтгэлийн аудит
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ХОХБТХ	Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ХААН	Хөдөө аж ахуйн банк
НББ	Нягтлан бодох бүртгэл
ТХШС	Төрийн хяналт шалгалтын стандарт
ААН	Аж ахуйн нэгж
ЖДҮ	Жижиг, дунд үйлдвэрлэл

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

1. Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг Монгол Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хорооны 2017 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 06 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/125 дугаар тушаал, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудиторын 2018 оны А/22 дугаар тушаалыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийв.

2. Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандартын талаарх мэдээлэл

Хөвсгөл аймагт хэрэгжиж буй “Орон нутгийн эргэн төлөгдөх зээлийн сан”-уудын олголттой холбоотой 2016 он, 2017 он, 2018 оны эхний хагас жилийн үйл ажиллагааг шалган дүгнэлт, зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулах, үр дүнг олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдлээ.

Аудитын зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэв. Үүнд:

- ❖ Өрх гэрийн үйлдвэрлэлийг дэмжих сан, Бүс нутгийн хөгжлийг дэмжих сан, аймгийн Үйлдвэржилтийг дэмжих сангуудын хөрөнгийн бүрдүүлэлт, хуваарилалт, төсөл сонгон шалгаруулалтыг холбогдох хууль, дүрэм, журмын дагуу зохион байгуулсан эсэх
- ❖ Зээлийн сангуудын хөрөнгийг зориулалтын дагуу үр дүнтэй, үр нөлөөтэй зарцуулсан эсэх болон зээлийн ашиглалтын үр нөлөөт байдал, түүнд тавих төрийн байгууллагуудын хяналт үр дүнтэй эсэх

Аудитад аймгийн ИТХ, ЗДТГ, ЗДТГ-ын СТСХ, ХОХБТХ, ХААН банкны Хөвсгөл аймаг дахь салбар, сумдын ИТХ, ЗДТГ, төсөл сонгон шалгаруулах хороо болон зээлийн сангуудаас зээл аван үйл ажиллагаа явуулж буй ЖДҮ эрхлэгчдийг хамруулан 2016 он, 2017 он, 2018 онуудын зээлийн төсөл сонгон шалгаруулахтай холбоотой баримт материал, зээл олголттой холбоотой мэдээ, судалгааны материалд тулгуурлан гүйцэтгэв.

3. Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхдээ Төрийн хяналт шалгалтын стандарт, Гүйцэтгэлийн аудитын удирдамж АДБОУС 3000-3100, Гүйцэтгэлийн аудитын журмыг мөрдөж, санхүүгийн болон гүйцэтгэлийн аудитын арга зүйг ашиглан, холбогдох асуудлаар аудитад хамрагдсан байгууллагаас тайлбар, асуулга авах, дүн шинжилгээ хийх зэрэг аудитын горимыг гүйцэтгэж, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулан ажиллалаа.

4. Шалгуур үзүүлэлтүүд

Аудитын зорилттой холбоотой дараах хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг шалгуур болгон ашигласан. Үүнд:

- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Иргэний хууль
- Засгийн газрын тусгай сангийн тухай хууль
- Жижиг дунд үйлдвэрийн тухай хууль
- Банкны тухай хууль
- Компаний тухай хууль
- Хоршооны тухай хууль
- Нөхөрлөлийн тухай хууль
- Дээрх хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гаргасан УИХ, Засгийн газрын тогтоол, бусад эрхийн актууд
- Аймгийн ИТХ-аас гаргасан тогтоол, шийдвэрүүд
- Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр
- Аймаг, сумын Засаг дарга банктай байгуулсан гэрээнүүд
- Холбогдох бусад хууль тогтоомж, эрх зүйн актууд.

5. Аудитын бүрэлдэхүүн

Аудитыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор О.Ганболд удирдаж, үе шатны болон явцын хяналтыг аудитын менежер Ж.Отгончимэг хэрэгжүүлж, аудитор Э.Бат-Эрдэнэ 2018 оны 09 дүгээр сарын 03-аас 2018 оны 10 дугаар сарын 31-ний хооронд гүйцэтгэв.

6. Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгагдах мэдээлэл, хэлэлцүүлэх журам

Аудитын тайлан нь аудитын зорилтууд, хамрах хүрээ, арга зүй, тайлангийн хураангуй, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж, холбогдох байгууллагын санал, түүнд хийсэн тайлбар, хавсралт гэсэн агуулгаар үндсэн зорилтын дагуу бичигдсэн.

7. Үндсэн мэдээлэл

Өрх гэрийн үйлдвэрлэлийг дэмжих сангийн тухайд: УИХ-ын гишүүн Ц.Даваасүрэнгийн санаачлагаар Монгол Улсын 2009 оны Төсвийн тухай хуулийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнд “Өрх гэрийн үйлдвэрлэлийг дэмжих сан” төслийг хэрэгжүүлэхээр 388.0 сая төгрөг батлагдсан байна.

Сангийн хөрөнгийг эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр 2009 оны 06 дугаар сарын 01-ний өдөр аймгийн Засаг дарга, сумдын Засаг дарга нар, ЗООС банкны захиралтай “Аймаг орон нутгийн жижиг, дунд үйлдвэрийг дэмжих талаар хамтран ажиллах гэрээ”-г байгуулан сарын 1 хувийн хүүтэйгээр зээл хэлбэрээр олгож эхэлсэн байна.

2009 оны 11 дүгээр сараас ЗООС банкаар зээлийг цаашид үргэлжлүүлэн олгох боломжгүй болсон тул 2009 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр аймгийн Засаг дарга, ХААН банкны Хөвсгөл дахь салбарын захиралтай “Аймаг орон нутгийн жижиг, дунд үйлдвэрийг дэмжих талаар хамтран ажиллах гэрээ”-г байгуулсан байна.

Тухайн үед ЗООС банканд байсан зээлийн үлдэгдэл, эргэн төлөлтийг ХААН банкны 5890561431 тоот дансанд төвлөрүүлэн сангийн эх үүсвэрийг 400.0 сая төгрөг болгосон байна.

Аймгийн үйлдвэржилтийг дэмжих сангийн тухайд: Энэ сангийн эх үүсвэр нь “Лидер Кашмир” ХХК-д 2009 онд тоног төхөөрөмж худалдан авах зорилгоор олгосон зээлийн төлөгдөөгүй байсан үлдэгдлийг “Аймгийн үйлдвэржилтийг дэмжих сан”-ийн ХААН банкн дахь дансанд төвлөрүүлснээр бий болсон байна.

2017 оны 12 сарын 07 өдрийн гэрээгээр 155.0 сая төгрөгийн сан бүхий бүс орон нутгийн хөгжлийг дэмжих сан, 510.7 сая төгрөгийн сан бүхий аймгийн үйлдвэржилтийг дэмжих сангуудыг нэгтгэн **665.7** сая төгрөгийн сан бүхий “Аймгийн үйлдвэржилтийг дэмжих сан” болгосон байна.

Бүлэг 1: Төсөл хөтөлбөрийг гэрээ, журамд заасан заалттай нийцүүлэн сонгон шалгаруулаагүй байна.

1.1 Сангийн хөрөнгийн эргэн төлөлт хэвийн байна.

Өрх гэрийн үйлдвэрлэлийг дэмжих сан, аймгийн үйлдвэржилтийг дэмжих сангууд нь аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2016 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 20 дугаар тогтоолоор “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих орон нутгийн тусгай сан байгуулах, түүнд хөрөнгө төвлөрүүлэх захиран зарцуулах, хяналт тавих журам”-аар зохицуулагдаж байна.

Өрх гэрийн үйлдвэрлэлийг дэмжих сан болон аймгийн үйлдвэржилтийг дэмжих сангийн зээлийн эргэн төлөлт, төвлөрүүлэлт хэвийн байна.

Монгол Улсын 2009 оны Төсвийн тухай хуулийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнд “Өрх гэрийн үйлдвэрлэлийг дэмжих сан” төслийг хэрэгжүүлэхээр 400.0 сая төгрөг батлагдсан байна.


Энэхүү хөрөнгийг Мөрөн суманд 80.0 сая төгрөг, Хатгал тосгонд 12.0 сая төгрөг, бусад сум бүрт 14.0 сая төгрөг олгохоор хуваарилсан байна.

Зарим сумдын орон нутгийн удирдлагууд “Өрх гэрийн үйлдвэрлэлийг дэмжих сан”-ийн талаар мэдээлэл муутай, идэвх санаачлагагүй байгаагаас тухайн жилд хуваарилагдсан хөрөнгийг ашиглаагүй байна. **/Хүснэгт 1-ээс харна уу/**

Өрх гэрийн үйлдвэрлэлийг дэмжих сангийн тухайд: Хөвсгөл аймгийн Засаг дарга болон ХААН банкны Хөвсгөл салбарын захирал Д.Цэцгээ нарын 2016 оны 07 дугаар сарын 04-ний өдөр байгуулсан “Аймаг орон нутгийн жижиг, дунд үйлдвэрийг дэмжих талаар хамтран ажиллах” гэрээний 2.1 “*Өрхийн үйлдвэрлэлийг дэмжих чиглэлээр иргэд, аж ахуйн нэгжийн боловсруулсан төслийг тухайн суманд “Төсөл шалгаруулах хороо” байгуулж хэлэлцэж шийдвэрлэнэ. Уг хороо нь Сумын Иргэдийн Хурлын төлөөлөгч (намуудын төлөөлөл), сумын Засаг дарга, сумын Засаг даргын орлогч, аж ахуйн нэгжийн 1 төлөөлөл, иргэний 2 төлөөлөл нийт 7 хүнтэй байна. Иргэний төлөөллийг сумын иргэд хуралдаж дундаасаа, аж ахуйн нэгжийн төлөөллийг сумын Ажил олгогч эздийн холбооны хурлаас тус тус сонгосон байна. Хорооны дарга нь сумын Засаг дарга байна.*”-д төсөл сонгон шалгаруулах хороог байгуулахаар заасан байна.

Хөвсгөл аймгийн 24 сумаас 16 сум “Өрх гэрийн үйлдвэрлэлийг дэмжих сан”-аас зээл олгохтой холбогдуулан “Төсөл сонгон шалгаруулах хороо”-г байгуулаагүй, дээр дурдсан гэрээний 2.1 дэх заалтыг зөрчсөн байна. **График 1-ээр харуулав:**

Сумдын Засаг дарга нар “Төсөл сонгон шалгаруулах хороо” байгуулсан эсэх



“Өрх гэрийн үйлдвэрлэлийг дэмжих сан”-аас иргэдэд бага хүүтэй зээл олгохдоо “Аймаг орон нутгийн жижиг, дунд үйлдвэрийг дэмжих талаар хамтран ажиллах” гэрээний 3.1.7 (... А тал нь зөвхөн сумын Төсөл шалгаруулах хороогоор хэлэлцэж, баталсан төслийг В талд хүргүүлэх үүрэгтэй ...) -д заасны дагуу сумын Засаг даргаар ахлуулсан “Төсөл шалгаруулах хороо”-оор хэлэлцэгдэж шалгарсан төслийг ХААН банканд хүргүүлэхээр заасан байхад зарим сумдын Засаг дарга нар “Төсөл сонгон шалгаруулах хороо”-оор хэлэлцэгдээгүй төслийг ХААН банканд хүргүүлсэн байна. **/Хүснэгт 1 ээс харна уу/**

“Өрх гэрийн үйлдвэрлэлийг дэмжих сан”-ийн олголтын мэдээлэл
Хүснэгт-1

№	Сумын нэр	Олгосон зээлийн дүн /мян.төг/						Төслийн хороо байгуулсан эсэх	Нийт дүн /мян.төг/	Нийт тоо
		2016 он	Тоо	2017 он	Тоо	2018 он	Тоо			
1	Алаг-Эрдэнэ	11,700.0	5	7,950.0	3	-	-	Тийм	19,650.0	8
2	Арбулаг	-	-	17,000.0	3	-	-	Үгүй	17,000.0	3
3	Баянзүрх	11,000.0	3	11,500.0	3	-	-	Үгүй	22,500.0	6
4	Бүрэнтогтох	-	-	16,500.0	5	1,900.0	2	Үгүй	18,400.0	7
5	Галт	3,000.0	1	3,000.0	1	1,700.0	1	Үгүй	7,700.0	3
6	Жаргалант	12,000.0	3	-	-	-	-	Үгүй	12,000.0	3
7	Их-Уул	-	-	14,900.0	3	-	-	Тийм	14,900.0	3
8	Рашаант	7,400.0	1	32,000.0	8	-	-	Тийм	39,400.0	9
9	Рэнчинлхүмбэ	2,600.0	1	-	-	-	-	Үгүй	2,600.0	1
10	Тариалан	8,000.0	2	8,500.0	3	-	-	Тийм	16,500.0	5
11	Тосонцэнгэл	9,000.0	3	10,500.0	4	-	-	Үгүй	19,500.0	7
12	Түнэл	-	-	-	-	-	-	Үгүй	-	-
13	Төмөрбулаг	-	-	-	-	-	-	Үгүй	-	-
14	Улаан-Уул	4,500.0	1	9,100.0	4	-	-	Тийм	13,600.0	5

15	Ханх	5,000.0	1	10,000.0	3	-		Үгүй	15,000.0	4
16	Хатгал тосгон	7,700.0	5	6,500.0	4	4,900.0	4	Үгүй	19,100.0	13
17	Цагаан-Уул	3,000.0	1	13,500.0	3	2,000.0	1	Үгүй	18,500.0	5
18	Цагаан-Үүр	7,000.0	3	-		32,000.0	4	Тийм	39,000.0	7
19	Цагааннуур	-		5,000.0	1	-		Үгүй	5,000.0	1
20	Цэцэрлэг	18,300.0	12	12,850.0	6	10,000.0	5	Үгүй	41,150.0	23
21	Чандмань-Өндөр			44,000.0	5	-		Тийм	44,000.0	5
22	Шинэ-Идэр	3,000.0	1	-		4,000.0	1	Тийм	7,000.0	2
23	Эрдэнэбулган	-		10,000.0	1	-		Үгүй	10,000.0	1
24	Мөрөн	69,000.0	8	125,000.0	16	98,800.0	12	Үгүй	292,800.0	36
Нийт дүн		182,200.0	51	357,800.0	76	155,300.0	30	Тийм-8 Үгүй-16	695,300.0	

Хүснэгтээс харахад: 2016-2018 онуудад “Өрх гэрийн үйлдвэрлэлийг дэмжих сан”-аас зээл олгохтой холбогдуулан “Төсөл сонгон шалгаруулах хороо”-г байгуулаагүй 16 сумаас 2 сум огт зээл олгоогүй, 14 сум нийт **501250.0** мянган төгрөгийн 113 төсөлд гэрээнд заасан заалтыг баримтлахгүй, төслийг хэлэлцэхгүйгээр зээл олгосон байна.

“Өрх гэрийн үйлдвэрлэлийг дэмжих сан”-аас зээл олгохдоо төслийг “Төсөл сонгон шалгаруулах хороо”-оор хэлэлцэхгүйгээр шууд Засаг даргын тоотоор дэмжиж арилжааны банканд хүргүүлж байгаа нь сангийн хөрөнгийг иргэдэд тэгш хүртээмжтэй, шударга олгогдох боломжийг хязгаарлаж байна. Энэ нь сангийн хөрөнгийн ашиглалт, зээлийн зарцуулалт, төслийн үр дүнд сөрөг нөлөө үзүүлж байна.

Аймгийн үйлдвэржилтийг дэмжих сангийн тухайд: Төсөл сонгон шалгаруулахдаа аймгийн Засаг даргын 2016 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн А/190 дүгээр захирамжаар “Жижиг дунд үйлдвэрийг дэмжих орон нутгийн тусгай сан”-ийн төсөл сонгон шалгаруулах, хяналт тавих комиссын бүрэлдэхүүнийг баталсан байна.

Аймгийн үйлдвэржилтийг дэмжих сангийн төсөл сонгон шалгаруулах хороо 2017 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр хуралдаж иргэд, ААН-ээс ирүүлсэн 16 төслөөс 9 төслийг, 2018 оны 06 дугаар сарын 12-ны өдөр хуралдаж иргэд, ААН-ээс ирүүлсэн 10 төслөөс 6 төслийг тус тус дэмжсэн байна.

Төсөл сонгон шалгаруулах хорооны хурлын тэмдэглэлд аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2016 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих орон нутгийн тусгай сан байгуулах, түүнд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах, хяналт тавих журам”-ын 4 “Сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх сонгон шалгаруулах”-ийн 4.1-д заасан шалгуурууд болон 4.2-д заасан шаардлагуудыг хангаж буй эсэхийг дурдаагүй байна. Төсөл сонгон шалгаруулах хороо журмын 4.5¹ дахь

¹ Комисс нь иргэн, аж ахуйн нэгжийн ирүүлсэн төслийг энэхүү журмын 4.1, 4.2-т заасан шалгуур, шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянан үзэж, комиссын хурлаараа хэлэлцэн шийдвэрлэнэ. Комиссын шийдвэр гарсан өдрөөс хойш 14 хоногийн дотор дэмжигдсэн төслүүдэд зээл олгох талаар арилжааны банкинд төслүүдийг хүргүүлнэ.

заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна. Дэмжигдсэн төслүүдийг комиссын шийдвэр гарснаас хойш 4-8 сарын дараа арилжааны банканд албан тооттой хүргүүлсэн байна. /Аудитын явцад ЗДТГ-ын ХОХБТХ-ээс төсөл сонгон шалгаруулахтай холбоотой 2017 он, 2018 оны хурлын тэмдэглэлээс өөр баримт ирүүлээгүй болно./

1.2 Зээлийн ашиглалт, үр дүн сум бүрт харилцан адилгүй байна.

“Өрх гэрийн үйлдвэржилтийг дэмжих сан”-ийн тухайд: Төсөл хэрэгжсэнээс хойших хугацаанд зээлийн гэрээг 6 удаа шинэчлэн байгуулсан байна.
Үүнд:

1. “Аймаг, орон нутгийн жижиг, дунд үйлдвэрийг дэмжих талаар хамтран ажиллах гэрээ” №1-ийг 2009 оны 11 дүгээр сарын 01-нд
2. “Аймаг, орон нутгийн жижиг, дунд үйлдвэрийг дэмжих талаар хамтран ажиллах гэрээ” №2-ыг 2009 оны 12 дугаар сарын 25-нд
3. 01 тоот “Аймаг, орон нутгийн жижиг, дунд үйлдвэрийг дэмжих талаар хамтран ажиллах гэрээ”-нд нэмэлт өөрчлөлт оруулах тухай гэрээг 2009 оны 12 дугаар сард
4. “Аймаг, орон нутгийн жижиг, дунд үйлдвэрийг дэмжих талаар хамтран ажиллах гэрээ” №5-ыг 2011 оны 09 дүгээр сарын 26-нд
5. “Аймаг орон нутгийн жижиг, дунд үйлдвэрийг дэмжих талаар хамтран ажиллах гэрээ” 2014 оны 04 дүгээр сарын 24-нд
6. “Аймаг орон нутгийн жижиг, дунд үйлдвэрийг дэмжих талаар хамтран ажиллах гэрээ” №10-ыг 2016 оны 07 дугаар сарын 04-нд тус тус шинэчлэн байгуулсан байна.

2016 оны 07 дугаар сарын 04-нд байгуулагдсан №10 дугаар бүхий гэрээний 5.5 “Энэхүү гэрээ байгуулагдсанаар энэ асуудлаар өмнө нь байгуулагдсан бүх гэрээ, хэлцэл, тохиролцоо хүчингүй болно” гэж заасны дагуу өмнөх гэрээнүүд хүчингүй болж энэхүү гэрээ мөрдөгдөж байна.

Одоо мөрдөгдөж буй “Аймаг орон нутгийн жижиг, дунд үйлдвэрийг дэмжих талаар хамтран ажиллах гэрээ”-ний дараах заалтууд хэрэгжихгүй байна. Үүнд:

1. Гэрээний 2.1 (... Өрхийн үйлдвэрлэлийг дэмжих чиглэлээр иргэд, аж ахуйн нэгжийн боловсруулсан төслийг тухайн суманд “Төсөл шалгаруулах хороо” байгуулж хэлэлцэж, шийдвэрлэнэ. Уг хороо нь сумын Иргэдийн Хурлын 2 төлөөлөгч (намуудын төлөөлөл), сумын Засаг дарга, сумын Засаг даргын орлогч, аж ахуйн нэгжийн 1 төлөөлөл, иргэний 2 төлөөлөл нийт 7 хүнтэй байна. Иргэний төлөөллийг сумын иргэд хуралдаж дундаасаа, аж ахуйн нэгжийн төлөөллийг сумын Ажил олгогч эздийн холбооны хурлаас тус тус сонгосон байна ...)
2. Гэрээний 2.4.7 (... Зээлийг зөвхөн үйлдвэрлэл эрхлэгч иргэд аж ахуйн нэгжид олгох бөгөөд худалдааны санхүүжилт болон хувийн хэрэгцээнд олгохгүй байх”

3. Гэрээний 3.1.7 (... А тал зөвхөн сумын Төсөл шалгаруулах хороогоор хэлэлцэж, баталсан төслийг В талд хүргүүлэх үүрэгтэй ...)
4. Гэрээний 3.2.7 (... В тал нь сумдын иргэд, аж ахуйн нэгжид олгосон зээл эргэн төлөгдөж дуусахад эх үүсвэрийг буцаан шилжүүлнэ ...)
5. Гэрээний 3.2.9 (... В тал нь “Төсөл шалгаруулах хороо”-нд зээл судлахад зайлшгүй удирдлага болгох зөвлөмжийг гаргаж өгөх үүрэгтэй. Энэхүү зөвлөмжид зээл судлахад зайлшгүй бүрдүүлэх материал, барьцаа хөрөнгийн шаардлагын талаар заасан байна ...)
6. Гэрээний 3.2.12 (... Сангийн мөнгөн хөрөнгийн зарцуулалт, үлдэгдэл, зээлийн эргэн төлөлтийн тухай ерөнхий тоон мэдээллийг олон нийтэд нээлттэй байлгаж, А талд мэдэгдэнэ ...)

“Аймгийн үйлдвэржилтийг дэмжих сан”-ийн тухайд: “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих орон нутгийн тусгай сангийн зээл олгох талаар хамтран ажиллах гэрээ”-ний дараах заалтууд хэрэгжихгүй байна. Үүнд:

1. Гэрээний 2.7 (... Зээлийг зөвхөн үйлдвэрлэл эрхлэгч иргэд, аж ахуйн нэгжид олгох бөгөөд худалдааны санхүүжилт болон хувийн хэрэгцээнд олгохгүй ...)
2. Гэрээний 2.8 (... Зээлдэгч нь сангаас олгосон зээлийг зориулалт бусаар ашигласан нөхцөлд шууд татан төлүүлнэ ...)
3. Гэрээний 3.1.1 (... Энэ гэрээний “В” талд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж байгаа эсэхэд хяналт тавих ...)
4. Гэрээний 3.1.11 (... Сангаас зээл авсан харилцагч нар үйлдвэрлэлийнхээ үйл ажиллагааг явуулж байгаа эсэхэд “А” тал хяналт тавина. Зээлдэгч зориулалтын дагуу үйл ажиллагаагаа явуулаагүй нөхцөлд “В” талд мэдэгдэж зээл төлүүлэх талаар хамтран арга хэмжээ авна ...)

Гэрээний гол гол заалтууд хэрэгжихгүй, гэрээг дүгнэхгүй байгаа нь зээлийн ашиглалт, хэрэгжилт, хүрэх үр дүнд сөргөөр нөлөөлж байна.

“Өрх гэрийн үйлдвэрлэлийг дэмжих сан”-ийн тухайд:

Банкны шалгуур хангаж зээл олгосон байдлыг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 2:


Огноо	Төсөлд хамрагдсан өрхийн тоо	Олгосон зээлийн эхний үлдэгдэл	Тухайн онд олгосон зээлийн дүн	Эргэн төлөлт	Олгосон зээлийн эцсийн үлдэгдэл
2016	41	240,904.4	182,200.0	223,119.2	199,985.2
2017	76	199,985.2	357,800.0	225,600.1	332,185.1
2018	30	332,185.1	155,300.0	222,915.6	264,569.5
Дүн			147		

2016-2018 онуудад дараах сумд “Өрх гэрийн үйлдвэрлэлийг дэмжих сан”-аас зээл огт олгоогүй, зээлийн олголт хангалтгүй, ашиглалт “МУУ” байна. **Дэлгэрэнгүй хүснэгт 1-ээс харна уу.** Үүнд:

1. Түнэл сум /зээл огт олгоогүй/
2. Төмөрбулаг сум /Зээл огт олгоогүй/
3. Рэнчинлхүмбэ сум /1 зээл олгосон/
4. Цагааннуур сум /1 зээл олгосон/
5. Эрдэнэбулган сум / 1зээл олгосон/
6. Шинэ-Идэр сум /2 зээл олгосон/

2016-2018 онуудад дараах сумд “Өрх гэрийн үйлдвэрлэлийг дэмжих сан”-ийн эх үүсвэрийг “**САЙН**” ашигласан байна. Үүнд:

1. Мөрөн сум /36 зээл олгосон, зээлийн эргэц-1.2/
2. Цэцэрлэг сум / 23 зээл олгосон, зээлийн эргэц-0.9/
3. Хатгал тосон /13 зээл олгосон, зээлийн эргэц-0.5/



2016-2018 онуудад “Өрх гэрийн үйлдвэрлэлийг дэмжих сан”-аас олгогдсон зээлийн үзүүлэлтийг харахад 2017 онд хамгийн өндөр үзүүлэлттэй буюу 76 зээлдэгчид 357,800.0 мянган төгрөгийн зээл олгосон байна. **График 2-оор харуулав:**

2018 оны байдлаар 16 сум “Өрх гэрийн үйлдвэрлэлийг дэмжих сан”-аас огт зээл олгоогүй, “Төсөл сонгон шалгаруулах хороо” зээлийн эх үүсвэрийг хангалттай ашиглаж чадаагүй нь зээл олголтын түвшинг бууруулсан байна.

Зээлийн эх үүсвэрийг бүрэн ашиглаж чадахгүй байгаа шалтгаан:

1. Ихэнх суманд “Төсөл сонгон шалгаруулах хороо” байгуулаагүйгээс Засаг даргын тоотой дэмжигдсэн төслүүд арилжааны банканд хүргэгдээд “Банкны шаардлага хангахгүй” гэсэн шалтгаанаар хэрэгжээгүй байна.
2. Сумын удирдлагууд арилжааны банканд хэдэн төгрөгийн чөлөөт эх үүсвэр байгааг мэдэхгүй, банктэй харилцан мэдээлэл солилцож хамтран ажилладаггүй байна.
3. Сумын удирдлагууд “Өрх гэрийн үйлдвэрлэлийг дэмжих сан”-ийн талаар иргэдэд мэдээлдэггүй, хэрхэн төсөл бичих, зээлд хамрагдах талаар заавар зөвлөгөө өгдөггүй байна.

4. “Өрх гэрийн үйлдвэрлэлийг дэмжих сан”-аас зээл авч хэрэгжсэн төслүүдэд явцын хяналт хийдэггүй, хэлэлцдэггүйгээс зээлийн чанар, ашиглалтад нөлөөлж байна.
5. Зарим сумд сангийн эх үүсвэрийг бүрэн ашиглахгүй байгаагаас бусад сумдад ашиглуулсан байна. **Жишээ нь:** 2017 онд Чандмань-Өндөр суманд 44,000.0 мянган төгрөг, 2018 онд Цагаан-Үүр суманд 32,000.0 мянган төгрөг болгон эх үүсвэрийг нэмэгдүүлж олгосон байна.

Сумдын “Төсөл сонгон шалгаруулах хороо”-ны ажлыг сайжруулан “Өрх гэрийн үйлдвэрлэлийг дэмжих сан”-ийн зээлийн олголт, үйл ажиллагаанд анхаарч ажиллах шаардлагатай байна.

“Аймгийн үйлдвэржилтийг дэмжих сан”-ийн тухайд:

Банкны шалгуур хангаж зээл олгосон байдлыг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 3:

Огноо	Төсөлд хамрагдсан өрхийн тоо	Олгосон зээлийн эхний үлдэгдэл	Тухайн онд олгосон зээлийн дүн	Эргэн төлөлт	Олгосон зээлийн эцсийн үлдэгдэл
2016	8	425,676.0	255,000.0	131,219.4	549,456.6
2017	2	549,456.6	67,100.0	170,344.4	446,212.2
2018	8	446,212.2	300,000.0	156,283.9	589,928.3
Дүн			18		

Хүснэгтээс харахад: Зээлийн ашиглалт он бүрт харилцан адилгүй байна. “Бүс нутгийн хөгжлийг дэмжих сан” болон “Аймгийн үйлдвэржилтийг дэмжих сан” нэгдсэнээр 2018 онд зээлийн олголт өссөн үзүүлэлттэй байна.

Сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төслийн хэрэгжилтэд явцын хяналт хийхэд төсөлд тусгагдсан ажлын байрны тоо бий болоогүй ихэвчлэн 1-2 хүний орон тоотой байна.

“Аймгийн үйлдвэржилтийг дэмжих сан”-ийн хөрөнгөөс зээл олгохдоо журамд заасан шалгуур, шаардлагыг баримтлан төслийг сонгон шалгаруулах, зээлийн ашиглалт, чанар, зарцуулалт, хүрэх үр дүнд явцын хяналт хийн, байнгын ажлын байр бий болгоход түлхүү анхаарч ажиллах шаардлагатай байна.

Бүлэг 2: Сангийн хөрөнгийн зарцуулалтад холбогдох байгууллагууд хяналт тавиагүй байна.

2.1 Сангийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй төслийн үйл ажиллагаанд хяналт тавиагүйгээс шалгарсан төслүүд хэрэгжихгүй, үр дүнгүй болох нөхцөл бүрдсэн байна.

“Өрх гэрийн үйлдвэрлэлийг дэмжих сан”-ийн тухайд: Томилолтоор ажилласан сумдын сангийн хөрөнгийн зарцуулалтад хяналт шалгалт хийхэд зориулалт бусаар зарцуулсан тохиолдол байна . **Тухайлбал:**

Чандмань-Өндөр сумын 2017 онд олгосон зээлүүдээс дараах зээлдэгчид төсөл, хөтөлбөрийг гэрээнд заасан зориулалтын дагуу ашиглаагүй нийт 24.0 сая төгрөгийн зөрчил байна. **Үүнд:**

1. Ц.Оюунсүрэнгийн /Зөгийн аж ахуй-10.0 сая төгрөг/
2. Г.Ганбаярын /Авто сэлбэгийн худалдаа- 6.0 сая төгрөг/
3. Б.Хатанзоригийн /Эргэлтийн хөрөнгө тоног төхөөрөмж 8.0 сая төгрөг/

Аймгийн үйлдвэржилтийг дэмжих сангийн тухайд: 2018 оны 10 дугаар сарын 30-ны байдлаар нийт 22 зээл үлдэгдэлтэй байна. Зээл авсан иргэд, ААН-ийн үйл ажиллагаанд аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-ийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, ХААН банкны зээл хариуцсан харилцааны менежертэй хамтран шалгалт хийхэд төсөл бүрэн хэрэгжээгүй зогссон, төслийн ашиглалт, үр дүн хангалтгүй тохиолдлууд байна. **/Дэлгэрэнгүйг хавсралт 1-ээс харна уу/ Тухайлбал:**

1. 2018 оны 10 дугаар сарын 30-ны байдлаар зээлийн үлдэгдэлтэй байгаа 22 зээлдэгчээс 5 зээлдэгчийн үйл ажиллагаа зогссон, ашиглалтгүй, хүрэх үр дүндээ хүрээгүй байна. /272.1 сая төгрөгийн төсөл хэрэгжээгүй, зогссон/
/Албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв./

“Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих орон нутгийн тусгай сан байгуулах, түүнд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах, хяналт тавих журам”-ын 5.5 “Сангийн хөрөнгийн нягтлан бодох бүртгэлийг төсөл сонгон шалгаруулах комиссын нарийн бичгийн дарга хариуцна”-д сангийн нягтлан бодох бүртгэлийг ХОХБТ-ийн хэлтсийн жижиг дунд үйлдвэрлэл хариуцсан мэргэжилтэн хариуцахаар заасан боловч хэрэгжилт хангагдахгүй тухайн ажилтны ажлын үндсэн чиг үүрэгт хамаарахгүй байна. Иймд дээрх журмын заалтад өөрчлөлт оруулж ажиллах нь зүйтэй гэж гүйцэтгэлийн аудитаар үзэж байна.

2.2 Эрх бүхий албан тушаалтнууд сангийн үйл ажиллагаатай холбоотой үүргээ хэрэгжүүлээгүй, хөрөнгийн зарцуулалтад хяналт шалгалт хийгээгүй байна.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал сангийн хөрөнгөөс зээл олгох, зарцуулах, хяналт тавих, зээлийг эргэн төлүүлэх, тайлагнахтай холбоотой дараах эрх үүргийг хэрэгжүүлэхээр журамд тусгажээ. **Үүнд:**

- 1.1.1 Сангийн хөрөнгөөр зээл олгохтой холбогдуулан аймгийн хөгжлийн тэргүүлэх чиглэлийг орон нутагт жижиг, дунд үйлдвэр хөгжүүлэх, иргэдийн орлогыг нэмэгдүүлэх, ажлын байр бий болгох зорилгод уялдуулж тодорхойлно.
- 1.1.2 Сангийн үйл ажиллагааны тайланг жил бүр хэлэлцэн үр дүнг тодорхойлж, чиглэл өгөх

2017-2018 онуудад аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал журамд заагдсан дээрх эрх үүргийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Аймгийн Засаг дарга сангийн үйл ажиллагаатай холбогдон 8 эрх, үүргийг хэрэгжүүлэхээр журамд тусгасан боловч дараах эрх үүргүүдийг хэрэгжүүлж ажиллаагүй байна. **Үүнд:**

1. Аймгийн хэмжээнд төсөл сонгон шалгаруулахад иргэдийн оролцоог хангах, сангийн үйл ажиллагаатай холбогдох мэдээллийг ил тод мэдээлэх, шилэн дансанд байршуулах арга хэмжээ авах
2. Комиссын бүрэлдэхүүний ажил үүргийн хуваарийг тодорхой тусгаж, ажиллах дүрмийг батлах
3. Сангийн зарцуулалт, үйл ажиллагааны үр дүнгийн талаарх тайлан мэдээг бэлтгэн аймгийн ИТХ-д жил бүр тайлагнан үр дүнг хариуцах.
4. Төсөл нь шалгарч зээлд хамрагдсан иргэн, аж ахуй нэгжийн зээлийн ашиглалт, эргэн төлөлтөд хяналт тавих талаар гэрээ байгуулсан арилжааны банктай хамтран ажиллах.

2017-2018 онуудад аймгийн Засаг дарга сангийн үйл ажиллагаатай холбоотой эрх үүргийн **50** хувийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

ЗДТГ-ын ХОХБТХ-ийн дарга нь сангийн үйл ажиллагаа, зээлийн хэрэгжилтийн талаарх тайланг 2017-2018 онуудад аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хуралд тайлагнаагүй журмын 5.4²-д заасан заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

² “Сангийн үйл ажиллагаа, зээлийн хэрэгжилтийн талаарх тайлан, мэдээг жил бүр аймгийн иргэдийн санхүүгийн нэгдсэн тайланд оруулахаар Санхүү, төрийн сангийн хэлтэст хүргүүлнэ. Мөн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хуралд жил бүр тайлагнаж байх ажлыг аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлогын хэлтсийн дарга хариуцна

Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих орон нутгийн тусгай сангийн зээл олгох талаар хамтран ажиллах гэрээний 3.1.11³-д хяналт тавих тухай заасан байхад Хөвсгөл аймгийн ЗДТГ-аас “Аймгийн үйлдвэржилтийг дэмжих сан”-ийн үйл ажиллагаанд 2016-2018 онуудад хяналт тавьж ажиллаагүй байна.

Энэ нь сангийн хөрөнгөөс зээл авсан ААН, иргэд гэрээнд заасан зориулалтаас өөр зүйлд зарцуулах эрсдэлийг бий болгосон байна.

Хөвсгөл аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2016 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн 20 дугаар тогтоол “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих орон нутгийн тусгай сан байгуулах, түүнд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах, хяналт тавих журам”-ын 6.5 “*Сангийн хөрөнгөнд санхүүгийн хяналт, дотоод аудитын алба, улсын байцаагчид дотоод хяналт хийж, үр дүнг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд болон Засаг даргад танилцуулж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлнэ*”-д заасны дагуу Санхүүгийн хяналт, аудитын алба 2016-2018 онуудад хяналт шалгалт хийгээгүй байна.

Гүйцэтгэлийн аудитаар нийт 1,021.4 сая төгрөгийн зөрчил илэрч 187.1 сая төгрөгийн 4 төслийг хугацаанаас нь өмнө цуцалж, зээлийн үлдэгдлийг татах тухай албан шаардлага хүргүүлж ажиллаа.

³ Сангаас зээл авсан харилцагч нар үйлдвэрлэлийнхээ үйл ажиллагааг явуулж байгаа эсэхэд “А” тал хяналт тавина. Зээлдэгч зориулалтын дагуу үйл ажиллагаагаа явуулаагүй нөхцөлд “В” талд мэдэгдэж зээл төлүүлэх талаар хамтран арга хэмжээ авна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. **Үүнд:**

1. Зээлийн эргэн төлөлт, бүрдүүлэлт хэвийн байна.
2. “Өрх гэрийн үйлдвэрлэлийг дэмжих сан”-аас зээл олгохтой холбоотой орон нутагт “Төсөл сонгон шалгаруулах хороо” байгуулж ажиллаагүй байна.
3. “Өрх гэрийн үйлдвэрлэлийг дэмжих сан”-аас зээл олгохдоо сумдын Засаг дарга нар “Төсөл сонгон шалгаруулах хороо”-оор хэлэлцэгдээгүй төслийг ХААН банканд хүргүүлж байгаа нь зээлийн олголт, ашиглалт, үр дүнд сөргөөр нөлөөлж байна.
4. Төсөл хөтөлбөрийг гэрээ, журамд заасан заалттай нийцүүлэн сонгон шалгаруулаагүй байна.
5. Сангийн хөрөнгийн үйл ажиллагаатай холбоотой баримт материалын бүрдэлт хангалтгүй, мэдээллийн сан байхгүй, холбогдох байгууллагууд уялдаа холбоогүй ажилласан байна.
6. Орон нутгийн болон мэргэжлийн байгууллага, эрх бүхий албан тушаалтнууд хууль журамд заасан эрх, үүргээ бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.
7. Сангийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй төслийн үйл ажиллагаанд хяналт тавиагүйгээс шалгарсан төслүүд хэрэгжихгүй, үр дүнгүй болох төслийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулах нөхцөл бүрдсэн байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна. **Үүнд:**

ИТХ-ын дарга Л.Төмөрбаатарт:

1. “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих орон нутгийн тусгай сан байгуулах, түүнд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах, хяналт тавих журам”-д заасан эрх үүргийн дагуу сангийн үйл ажиллагааны тайланг жил бүр хэлэлцэн үр дүнг тодорхойлж чиглэл өгч байх.

Аймгийн Засаг дарга Л.Ганболдод:

1. “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих орон нутгийн тусгай сан байгуулах, түүнд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах, хяналт тавих журам”-д заасны дагуу сангийн үйл ажиллагаатай холбоотой эрх үүргийг бүрэн хэрэгжүүлж ажиллах.

ИТХ-ын нарийн бичгийн дарга Ц.Гончигт:

1. Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2016 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн 20 дугаар тогтоол “Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих орон нутгийн тусгай сан байгуулах, түүнд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах, хяналт тавих журам”-ын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах.

Аймгийн ЗДТГ-ын дарга Х.Ган-Очирт:

1. Сангаас зээл олгох талаар ХААН банкны Хөвсгөл дахь салбартай байгуулсан хамтран ажиллах гэрээний холбогдох заалтуудыг хэрэгжүүлж ажиллах.
2. Сангаас зээл авсан харилцагч нар гэрээнд заасан чиглэлээр үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулж буй эсэхэд хяналт тавьж ажиллах.

ЗДТГ-ын ХОХБТХ-ийн дарга Э.Аззаяа-д:

1. Сангийн хөрөнгөөс зээл олгохтой холбоотой төсөл сонгон шалгаруулахдаа журамд заасан шалгуур, шаардлагыг баримталж ажиллах.
2. Сангийн үйл ажиллагаа, зээлийн хэрэгжилтийн талаарх тайлан, мэдээг жил бүр аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хуралд тайлагнах.
3. “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих орон нутгийн тусгай сан байгуулах түүнд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах, хяналт тавих журам”-ын зарим заалтуудад холбогдох хууль журмын дагуу өөрчлөлт оруулах.

Санхүү хяналт, аудитын албаны дарга В.Нэргүйд:

1. Сангийн хөрөнгөнд дотоод хяналт хийж, үр дүнг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хуралд болон Засаг даргад танилцуулж байх.

Сумын Засаг дарга нарт:

1. “Өрх гэрийн үйлдвэрлэлийг дэмжих сан”-аас зээл олгохтой холбоотой төсөл шалгаруулах хороо байгуулаагүй сумууд “Төсөл шалгаруулах хороо”-г байгуулж ажиллах.
2. “Төсөл шалгаруулах хороо”-оор хэлэлцэж, баталсан төслийг банканд хүргүүлж байх.
3. “Өрх гэрийн үйлдвэрлэлийг дэмжих сан”-ийн зээлийн олголт, үлдэгдлийн талаар иргэдэд ил тод мэдээлж байх

ХОХБТХ-ийн ахлах мэргэжилтэн З.Отгонбаярт:

1. Сангийн үйл ажиллагаатай холбоотой баримт материал, мэдээллийн санг бүрдүүлж ажиллах
2. Зээл олголт, эргэн төлөлт, зээлийн эх үүсвэрийн талаарх мэдээллийг сар бүр банктай тулган авч байх, мэдээлэл солилцож ажиллах.

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	2018.10.30	Аудитын нэр:	“Орон нутгийн хөрөнгийн эргэн төлөгдөх зээлийн сангуудын үйл ажиллагаа, үр дүн”	Аудитын код:	ХӨА-2018/02/-ГА
Шалгагдсан байгууллагын нэр:		Аймгийн ИТХ, ЗДТГ, ХОХБТХ, Сумдын ЗДТГ, Санхүү хяналт аудитын алба			Сая төгрөгөөр

№	Аудитын зорилт чиглэл	Тоо	Аудитын зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл			Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
					Нэр	Огноо	Дугаар	Албан тушаал	Овог нэр
1	Хөвсгөл аймагт хэрэгжиж буй “Орон нутгийн эргэн төлөгдөх зээлийн сан”-уудын олголттой холбоотой 2016 он, 2017 он, 2018 оны эхний хагас жилийн үйл ажиллагааг	1	2016-2018 онуудад “Өрх гэрийн үйлдвэрлэлийг дэмжих сан”-аас зээл олгохтой холбогдуулан “Төсөл сонгон шалгаруулах хороо”-г байгуулаагүй 16 сумаас 2 сум огт зээл олгоогүй, 14 сум нийт 501,250.0 мянган төгрөгийн 113 төсөлд гэрээнд заасан заалтыг баримтлахгүй, төслийг хэлэлцэхгүйгээр зээл олгосон байна.	501.2	Зөвлөмж	2018.10.31		Сумын Засаг дарга нар /16 сум/	
		1	Аймгийн үйлдвэржилтийг дэмжих сангийн төсөл сонгон шалгаруулах хороо 2017 онд 16 төслөөс 9 төслийг, 2018 онд 10 төслөөс 6 төслийг тус тус дэмжсэн боловч журмын 4.5 дахь заалтыг	520.2	Зөвлөмж			“Төсөл шалгаруулах хороо”-ны дарга, гишүүд	Х.Ган-Очир Төслийн багийн гишүүд.

шалган дүгнэлт, зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулах, үр дүнг олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэнэ.	1	хэрэгжүүлж ажиллаагүй байна. Сонгогдсон төслөөс бүрэн хэрэгжээгүй зогссон, төслийн ашиглалт, үр дүн хангалтгүй 272.1 сая төгрөгийн 5 төсөл байна. Үүнээс 187.1 сая төгрөгийн 4 төсөлд албан шаардлага хүргүүлэхээр боллоо.	-	Албан шаардлага	-	ЗДТГ-ын дарга	Х.Ган-Очир
	1	“Аймаг орон нутгийн жижиг, дунд үйлдвэрийг дэмжих талаар хамтран ажиллах гэрээ”-ний дараах заалтуудыг хэрэгжүүлээгүй байна. Үүнд: Гэрээний 2.1, 2.4.7, 3.1.7, 3.2.7, 3.2.9 дэх заалтууд.	-	Зөвлөмж	-	ЗДТГ-ын дарга	Х.Ган-Очир
	1	“Аймгийн үйлдвэржилтийг дэмжих сан”-ийн тухайд: “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих орон нутгийн тусгай сангийн зээл олгох талаар хамтран ажиллах гэрээ”-ний дараах заалтууд хэрэгжихгүй байна. Үүнд: Гэрээний 2.7, 2.8, 3.1.1, 3.1.11 дэх заалтууд	-	Зөвлөмж	-	ЗДТГ-ын дарга	Х.Ган-Очир
	1	2017-2018 онуудад аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал журмын 1.1.1, 1.1.2-т заасан эрх үүргээ хэрэгжүүлээгүй байна.	-	Зөвлөмж	-	ИТХ-ын дарга	Л.Төмөрбаатар
	1	2017-2018 онуудад аймгийн Засаг дарга сангийн үйл ажиллагаатай холбоотой эрх үүргийн 50 хувийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.	-	Зөвлөмж	-	Аймгийн Засаг дарга	Л.Ганболд

		1	ЗДТГ-ын ХОХБТХ-ийн дарга нь сангийн үйл ажиллагаа, зээлийн хэрэгжилтийн талаарх тайланг 2017-2018 онуудад аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хуралд тайлагнаагүй журмын 5.4 дэх заалтыг зөрчсөн байна.	-	Зөвлөмж			ЗДТГ-ын ХОХБТХ-ийн дарга	Э.Аззаяа
		1	Санхүүгийн хяналт, аудитын алба 2016-2018 онуудад журмын 6.5 д заасны дагуу хяналт шалгалт хийгээгүй байна.	-	Зөвлөмж			Санхүү хяналт, аудитын албаны дарга	В.Нэргүй
Нийт дүн			9	1021.4					

2014-2018 онд "Аймгийн үйлдвэржилтийг дэмжих сан"-аас олгосон зээлийн талаарх мэдээлэл

Хавсралт-1 /2018.10.30/

№	Сумын нэр	Зээлдэгчийн нэр	Олгосон огноо	Зээл хаагдах огноо	Олгосон мөнгөн дүн	Зээлийн үлдэгдэл	Төслийн нэр зориулалт	Тайлбар
1	Мөрөн	Д.Хишигбат	2015.06.04	2020.06.04	50,000.0	18,631.5	Алтан өд тахианы аж ахуйн төсөл	Үйл ажиллагаа нь зогсоод 2 жил болсон.
2	Мөрөн	ХӨВСГӨЛ КВАРК ХХК	2014.04.08	2019.04.08	85,000.0	74,985.1	Фермерийн аж ахуй	Үйл ажиллагаа зогссон. Шүүхийн шийдвэр гарсан
3	Мөрөн	ХӨВСГӨЛ ЭНХ МӨРӨН ХХК	2014.05.16	2019.05.16	50,000.0	8,370.5	Автоклавын хөнгөн бетон блокны үйлдвэр	Үйл ажиллагаа нь явуулахгүй байна.
4	Мөрөн	Д.Отгонбаяр	2014.05.29	2019.05.29	80,000.0	17,962.8	Нийтийн халуун ус	Үйл ажиллагаа явуулаагүй. Барилга дутуу баригдсан.
5	Мөрөн	Г.Эрдэнэчулуун	2016.01.11	2019.01.11	10,000.0	856.3	Авто засвар	Үйл ажиллагаа хэвийн
6	Мөрөн	Б.Цолмон	2016.06.08	2019.06.08	10,000.0	2,403.1	Авто засвар	Үйл ажиллагаа хэвийн
7	Мөрөн	Ц.Ганзориг	2016.08.17	2021.08.17	32,000.0	19,496.9	Чулуун гоёл, ажлын байр тоног төхөөрөмж	Үйл ажиллагаа хэвийн
8	Мөрөн	Н.Баттөр	2016.08.26	2021.08.26	100,000.0	69,014.7	Үйлчилгээний төв өргөтгөх	Үйл ажиллагаа хэвийн
9	Мөрөн	Гилаадайн гал хоршоо	2016.05.13	2019.05.13	18,000.0		Ногооны зорь	Үйл ажиллагаа хэвийн
10	Мөрөн	ТӨГС ХЯЗГААР ХХК	2017.09.04	2022.09.04	60,000.0	58,973.0	Мал нядалгааны шугам	Үйл ажиллагаа хэвийн
11	Мөрөн	НӨХӨРЛӨЛ ЗАМ ХОРШОО	2018.03.09	2021.03.09	85,000.0	67,610.6	Хүн тээврийн автобус худалдан авах	Үйл ажиллагаа хэвийн
12	Мөрөн	Ч.Энхбат	2018.04.25	2021.04.25	30,000.0	27,511.4	Тоног төхөөрөмж, гүний худаг, зорь	Ажил нь хийгдэж байна.
13	Мөрөн	Д.Отгондулам	2018.07.09	2023.07.09	50,000.0	50,000.0	Амьдрах ухаан, үндэсний үйлдвэрлэлийг өргөжүүлэх, ажлын байр бий болгох	Ажил нь хийгдэж байна.
14	Мөрөн	Б.Баасандорж	2018.07.28	2020.07.28	40,000.0	40,000.0	Хүнсний зорь барих	Үйл ажиллагаа хэвийн явагдаж байна.
15	Галт	И.Амгаланбаатар	2016.01.15	2019.01.15	50,000.0	6,134.5	Тоног төхөөрөмж худалдан авах	Үйл ажиллагаа хэвийн явагдаж байна.

“Орон нутгийн хөрөнгийн эргэн төлөгдөх зээлийн сангуудын үйл ажиллагаа, үр дүн” гүйцэтгэлийн аудитын тайлан

16	Жаргалант	Ажил бүтээл ХХК	2016.05.13	2021.05.13	30,000.0	20,309.4	Харуулдсан торх бэлтгэх	Үйл ажиллагаа хэвийн
17	Рэнчинлхүмбэ	Өсөх эрдэнийн сүмбэр	2018.08.27	2021.08.27	15,000.0	14,593.5	Хүүхдийн гутал үйлдвэрлэл	Үйл ажиллагаа хэвийн
18	Тариалан	Г.Эрдэнэбат	2018.08.20	2023.08.20	30,000.0	28,998.1	Талх нарийн боов үйлдвэрлэлтийн т/төхөөрөмж авах үйлдвэрийн байр барих	Үйл ажиллагаа хэвийн
19	Түнэл	А.Эрдэнэчулуун	2016.06.17	2019.06.17	5,000.0	1,176.0	Гэрийн мод модон эдлэлийн үйлдвэрлэл	Үйл ажиллагаа хэвийн
20	Цагаан-Үүр	Д.Ганбат	2018.02.13	2021.02.13	30,000.0	24,670.6	Мал мах түүхий эд худалдан авалт	Үйл ажиллагаа хэвийн
21	Цэцэрлэг	Л.Батдэлгэр	2014.05.05	2019.05.05	45,000.0	8,212.7	Шахмал түлш бэлтгэх	Үйл ажиллагаа хэвийн
22	Чандмань-Өндөр	Д.Энх-Амгалан	2017.11.02	2020.11.02	7,100.0	5,367.7	Зоогийн газар, караоке	Зарагдсан тул үйл ажиллагаа явуулахгүй байгаа.
23	Чандмань-Өндөр	В.Тосхүү	2018.02.15	2021.02.15	20,000.0	16,354.5	Барилгын материалын худалдаа	Үйл ажиллагаа хэвийн
Нийт дүн					932,100.0	581,632.9		



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОРЫН ТУШААЛ**

2018 оны 11 сарын 14 өдөр

Дугаар A/52

Мөрөн сум

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Монгол Улсын Ерөнхий аудиторов 2018 оны А/125 дугаар тушаал, 2017 оны А/188 дугаар тушаалын тавдугаар хавсралтын 2.4 дэх заалт, 2016 оны А/92 дугаар тушаалаар баталсан "Гүйцэтгэлийн аудитын журам"-ын 12.40 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан төлөвлөгөө хөтөлбөрийн дагуу "Орон нутгийн хөрөнгийн эргэн төлөгдөх зээлийн сангуудын үйл ажиллагаа, үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталсугай.

2. Аудитаар өгөгдсөн албан шаардлагыг хавсралтаар баталгаажуулсугай.

3. Аудитын тайланг Үндэсний аудитын газар, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, аймгийн Засаг дарга, аймгийн Засаг даргын Тамгын газар, Санхүүгийн хяналт, аудитын албанд тус тус хүргүүлсүгэй.

4. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж үр дүнг 2019 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн дотор багтаан Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга (Л.Төмөрбаатар), аймгийн Засаг дарга (Л.Ганболд), аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Х.Ган-Очир), Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны дарга (В.Нэргүй) нарт зөвлөсүгэй.

5. Гүйцэтгэлийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер (Ж.Отгончимэг), аудитор (Э.Бат-Эрдэнэ) нарт даалгасугай.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



О.ГАНБОЛД



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

67123. Хөвсгөл аймаг, Мөрөн сум, Урандеш баг
ЗДТГ-ын А корпус 3 давхар, Утас, факс: 70-38 37-93
Э-мэйл: khvsgul@audit.gov.mn
Вэбсайт: www.audit.mn

2018.11.22

№ ХА-2018/021-ТА-01/47

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН БОДЛОГО
ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН
ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ З.ОТГОНБАЯР
ТАНАА**

Зөрчил арилгуулах тухай

Монгол улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/125 дугаар тушаал, Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэсэн “Орон нутгийн эргэн төлөгдөх зээлийн сангуудын үйл ажиллагаа, үр дүн” гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

“Аймгийн үйлдвэржилтийг дэмжих сан”-аас 2014 онд “Автоклавын хөнгөн бетон блокны үйлдвэр”-ийн чиглэлээр 50.0 сая төгрөгийн зээл авсан Хөвсгөл Энх Мөрөн ХХК, 2017 онд “Зоогийн газар, караоке чиглэл”-ээр 7.1 сая төгрөгийн зээл авсан Д.Энх-Амгалан, 2014 онд “Нийтийн халуун ус”-ны чиглэлээр 80.0 сая төгрөгийн зээл авсан Д.Отгонбаяр, 2015 онд Алтан-Өд тахианы аж ахуй” төслөөр 50.0 сая төгрөгийн зээл авсан Д.Хишигбат нар нь гэрээнд заасан хугацаанд төслийг бүрэн хэрэгжүүлээгүй, үйл ажиллагаа явуулаагүй, хүрэх үр дүндээ хүрээгүй зогссон байхад аймгийн Засаг даргын Тамгын газраас хяналт тавиагүй, зөрчлийг таслан зогсооход арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Энэ нь “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих орон нутгийн тусгай сангийн зээл олгох талаар хамтран ажиллах гэрээ”-ний 3.1.11 (...Сангаас зээл авсан харилцагч нар үйлдвэрлэлийнхээ үйл ажиллагааг явуулж байгаа эсэхэд “А” тал хяналт тавина. Зээлдэгч зориулалтын дагуу үйл ажиллагаагаа явуулаагүй нөхцөлд “В” талд мэдэгдэж зээл төлүүлэх талаар хамтран арга хэмжээ авна ...), аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчдийн 2016 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн 20 дугаар тогтоолоор батлагдсан Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих орон нутгийн тусгай сан байгуулах, түүнд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах, хяналт тавих журам”-ын 6.3 (... Энэхүү журмын 4.2-т заасан этгээд авсан зээлээ үр ашиггүй, зарцуулсан, эсхүл зээлийн гэрээнд заасан зориулалтын дагуу зарцуулаагүй, зээл, түүний хүүг гэрээний хугацаа хэтрүүлж төлсөн, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй зэрэг тохиолдолд тухайн иргэн, аж ахуйн нэгжийн гэрээг хугацаанаас нь өмнө цуцлах, сангаас дахин зээл олгохгүй байна ...) дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т (... аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт, албан шаардлага өгөх ...) Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 4.1-д (... дараах алдаа зөрчилд төрийн аудитын байгууллага албан шаардлага өгнө ...) гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ НЬ:**

1. Дээрх зөрчилтэй төслүүдийн гэрээг хугацаанаас нь өмнө цуцалж, зээлийн үлдэгдлийг “Аймгийн үйлдвэржилтийг дэмжих сан”-д татан төвлөрүүлж биелэлтийг


1551420

2


2018 оны 01 дугаар сарын 25-ны өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн Засаг даргын тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч 3.Отгонбаярт даалгав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ӨГСӨН¹:

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор  Э.Бат-Эрдэнэ

Хянасан:

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер  Ж.Отгончимэг



ЗӨВШӨӨРСӨН:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч

3.Отгонбаяр



Х/22